

1. Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс хооронд нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр

А. ХЭЛЭЛЦЭЭРИЙН АГУУЛГА

Даатгуулагч Монгол Улс болон Оросын Холбооны Улсад шимтгэл төлж ажилласан хугацаагаа нэгтгэн тооцож байж аль нэг талын хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгох бол энэ асуудлыг хариуцсан хоёр улсын байгууллагад өргөдөл гарган зөвхөн ажилласан хугацаагаа нэгтгэн тооцуулж тэтгэвэр тогтоолгох боломжтой.

Хэрвээ даатгуулагч Монгол Улсад тэтгэвэр тогтоолгох бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу, Оросын Холбооны Улсад тэтгэвэр тогтоолгох бол Оросын Холбооны Улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллана. Харин Монгол-Оросын хамтарсан үйлдвэрт ажиллаж байгаа Оросын Холбооны Улсын иргэд Оросын Холбооны Улсын Тэтгэврийн санд, Монгол Улсын иргэд нь Монгол Улсын Нийгмийн даатгалд шимтгэлээ төлнө. Жишээ нь “Эрдэнэт Үйлдвэр”, “Монголросцветмет” гэх мэт байгууллагууд орно.

Б. ХЭЛЭЛЦЭЭРТ ХАМААРАХ ТЭТГЭВРИЙН ТӨРӨЛ

Дараах төрлийн тэтгэврийг Монгол Улс болон Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ:

- Тэтгэврийн даатгалын сангаас олгох өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр
- Тэтгэмжийн даатгалын сангаас олгох хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж

2. Монгол Улс, Бүгд Найрамдах Унгар Улсын хоорондын нийгмийн хамгааллын хэлэлцээр

А. ХЭЛЭЛЦЭЭРИЙН АГУУЛГА

Даатгуулагч Монгол улс болон Бүгд Найрамдах Унгар Улсад шимтгэл төлж ажилласан хугацаагаа нэгтгэн тооцож байж аль нэг талын хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгох бол энэ асуудлыг хариуцсан хоёр улсын байгууллагад өргөдөл гарган хугацаагаа нэгтгэн тооцуулж тэтгэвэр тогтоолгох боломжтой.

Хэвээ даатгуулагч Монгол улсад тэтгэвэр тогтоолгох бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу, Бүгд Найрамдах Унгар Улсад тэтгэвэр тогтоолгох бол Бүгд Найрамдах Унгар Улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллана.

Б. ХЭЛЭЛЦЭЭРТ ХАМААРАХ ТЭТГЭВРИЙН ТӨРӨЛ

Дараах төрлийн тэтгэврийг Монгол Улс болон БНУУ-ын хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

- Өндөр насны тэтгэвэр;
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр.

Монгол Улсын иргэн дараах нөхцлийг хангасан тохиолдолд Бүгд Найрамдах Унгар Улсаас өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрх үүснэ:

1. Бүгд Найрамдах Унгар Улсад ажиллаж, шимтгэл төлсөн байх
Үүнд Бүгд Найрамдах Унгар Улсад их, дээд сургуульд суралцсан хугацаа орно.
 2. Бүгд Найрамдах Унгар Улсын хууль тогтоомжид заасан өндөр насны тэтгэврийн нас /65 нас/-нд хүрсэн байх.
 3. Бүгд Найрамдах Унгар Улсын хууль тогтоомжоор тогтоосон тэтгэврийн даатгалын шимтгэл төлж ажилласан байвал зохих хугацаа /15-20 жил/-г хангасан байх;
- **Шимтгэл төлж ажилласан байвал зохих хугацаанд Монгол Улсад шимтгэл төлсөн хугацааг оруулан тооцно.**

3. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хооронд байгуулсан Нийгмийн хамгааллын хэлэлцээр

А. ХЭЛЭЛЦЭЭРИЙН ГОЛ АГУУЛГА:

Хоёр улсын иргэдийг тэтгэврийн даатгалд давхар даатгуулахгүйгээр өөрийн улсын тэтгэврийн даатгалд даатгуулах, хэрэв даатгуулсан тохиолдолд Солонгосын үндэсний тэтгэврийн албанд төлсөн шимтгэлийг нь буцаан олгох явдал юм.

Энэхүү хэлэлцээрээр БНСУ-д хөдөлмөр эрхэлж байгаа Монгол Улсын иргэд өөрийн орны тэтгэврийн даатгалд хамрагдаж, ирээдүйн амьдралын нийгмийн баталгаагаа хангах, тэтгэврийн даатгалын шимтгэлийг БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд давхар төлөхгүй, БНСУ-ын хуулийн дагуу заавал хамрагдах тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Б. ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ДАРААХ ХУУЛЬ ТОГТООМЖИД ХЭРЭГЛЭНЭ:

Монгол Улсын хувьд:

- Нийгмийн даатгалын тухай хууль,
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль,
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль,
- Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль.

Солонгос Улсын хувьд:

- Үндэсний тэтгэврийн тухай хууль,
- Хөдөлмөр эрхлэлтийн даатгалын тухай хууль,
- Хөдөлмөр эрхлэлтийн даатгал болон үйлдвэрлэлийн ослын нөхөн олговрын даатгалын шимтгэлийн хуримтлалын тухай хууль, дээрх хуулиудад хамаарах дүрэм зааврууд.

4. Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Польш Улс хоорондын хэлэлцээр

А.ХЭЛЭЛЦЭЭРИЙН ГОЛ АГУУЛГА:

Хоёр улсад тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцож, тэтгэвэр болон оршуулгын тэтгэмж тогтоох, олгох, тэтгэврийг харилцан шилжүүлэх, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны, жирэмсэн, амаржсаны, ажилгүйдлийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэмжүүдийг тогтоолгох боломжтой. Хэрвээ даатгуулагч Монгол улсад тэтгэвэр тогтоолгох бол Монгол улсын хууль тогтоомжийн дагуу, Бүгд Найрамдах Польш Улсад тэтгэвэр тогтоолгох бол Бүгд Найрамдах Польш Улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллана.

Б. ХЭЛЭЛЦЭЭРТ ХАМААРАХ ТЭТГЭВРИЙН ТӨРӨЛ

Дараах төрлийн тэтгэврийг Монгол Улс болон БНУУ-ын хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

Монгол Улсаас авах тэтгэврийн төрөл:

- Тэтгэврийн даатгалын сангаас олгох өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр;
- Тэтгэмжийн даатгалын сангаас олгох хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж;
- Ажилгүйдлийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж;
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох, тэтгэвэр, тэтгэмж.

Бүгд Найрамдах Польш Улсаас авах тэтгэврийн төрөл:

- Ажилгүйдлийн тэтгэмж (тариачдын нийгмийн даатгал болон нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж);
- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж;
- Өндөр насны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр;
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэмж;
- Оршуулгын тэтгэмж.

Монгол Улсын иргэн дараах нөхцлийг хангасан тохиолдолд Бүгд Найрамдах Польш Улсаас өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрх үүснэ:

4. Бүгд Найрамдах Польш Улсад ажиллаж, шимтгэл төлсөн байх;
 5. Бүгд Найрамдах Польш Улсын хууль тогтоомжид заасан өндөр насны тэтгэврийн нас /эмэгтэй-60, эрэгтэй 65 нас/-нд хүрсэн байх.
 6. Бүгд Найрамдах Польш Улсын хууль тогтоомжоор тогтоосон тэтгэврийн даатгалын шимтгэл төлж ажилласан байвал зохих хугацаа /эмэгтэй 20 жил, эрэгтэй 25 жил/-г хангасан байх;
- **Шимтгэл төлж ажилласан байвал зохих хугацаанд Монгол Улсад шимтгэл төлсөн хугацааг оруулан тооцно.**

5. Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд найрамдах Турк Улс хоорондын хэлэлцээр

А. ХЭЛЭЛЦЭЭРИЙН ГОЛ АГУУЛГА:

Монгол Улс болон Бүгд Найрамдах Турк Улсад шимтгэл төлсөн, төлж байгаа бүх иргэн хамаарах, хоёр улсад тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцож тэтгэвэр болон оршуулгын тэтгэмж тогтоох, олгох, тэтгэврийг харилцан шилжүүлэх, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр олгох явдал юм.

Хэрвээ даатгуулагч Монгол Улсад тэтгэвэр тогтоолгох бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу, Бүгд Найрамдах Турк Улсад тэтгэвэр тогтоолгох бол Бүгд Найрамдах Чех Улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллана.

Б. ХЭЛЭЛЦЭЭРТ ХАМААРАХ ТЭТГЭВРИЙН ТӨРӨЛ

Дараах төрлийн тэтгэврийг Монгол улс болон Бүгд Найрамдах Турк Улсын хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ:

- Өндөр насны тэтгэвэр,
- Оршуулгын тэтгэмж
- Мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр

Монгол Улсын иргэн дараах нөхцлийг хангасан тохиолдолд Бүгд Найрамдах Турк Улсаас өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрх үүснэ:

1. Бүгд Найрамдах Турк Улсад ажиллаж, шимтгэл төлсөн байх;
 2. Бүгд Найрамдах Турк Улсын хууль тогтоомжид заасан өндөр насны тэтгэврийн нас /эмэгтэй-58, эрэгтэй 60 нас/-нд хүрсэн байх.
 3. Бүгд Найрамдах Турк Улсын хууль тогтоомжоор тогтоосон тэтгэврийн даатгалын шимтгэл төлж ажилласан байвал зохих хугацаа /20 жил/-г хангасан байх;
- **Шимтгэл төлж ажилласан байвал зохих хугацаанд Монгол Улсад шимтгэл төлсөн хугацааг оруулан тооцно.**

6. Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр

А. ХЭЛЭЛЦЭЭРИЙН АГУУЛГА

Энэхүү хэлэлцээрээр хоёр улсын иргэд Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улсад шимтгэл төлж ажилласан давхардаагүй хугацаагаа нэгтгэн тооцуулж тэтгэвэр тогтоолгох, мөн тухайн улсад шимтгэл төлж ажилласан хугацаандаа ногдох тэтгэврийг шилжүүлэн авах нөхцөл бүрдэж, нийгмийн баталгаа нь хангагдах юм.

Б. ХЭЛЭЛЦЭЭРТ ХАМААРАХ ТЭТГЭВРИЙН ТӨРӨЛ

Дараах төрлийн тэтгэврийг Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улсын хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ:

Монгол Улсаас авах тэтгэврийн төрөл:

- Тэтгэврийн даатгалын сангаас олгох өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр;
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр;

Бүгд Найрамдах Чех Улсаас авах тэтгэврийн төрөл:

- Өндөр насны тэтгэвэр, тахир дутуугийн тэтгэвэр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тахир дутуугийн тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр;

Монгол Улсын иргэн дараах нөхцлийг хангасан тохиолдолд Бүгд Найрамдах Чех Улсаас тэтгэвэр тогтоолгон авах эрх үүснэ:

- Бүгд Найрамдах Чех Улсад ажиллаж, шимтгэл төлсөн байх;
Үүнд Бүгд Найрамдах Чех Улсад 1995.12.31-ний өдрөөс өмнө Бүгд Найрамдах Чех Улсын их, дээд сургуульд суралцсан хугацаа орно;
- Бүгд Найрамдах Чех Улсын хууль тогтоомжид заасан өндөр насны тэтгэврийн насанд хүрсэн байх;
- Бүгд Найрамдах Чех Улсын хууль тогтоомжоор тогтоосон тэтгэврийн даатгалын шимтгэл төлж ажилласан байвал зохих хугацаа /30 жил/-г хангасан байх.

- Бүгд Найрамдах Чех Улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр тогтоох нас:

Төрсөн он	Өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас
1960	64 нас 2 сар
1961	64 нас 4 сар
1962	64 нас 6 сар
.....	1 жил тутамд 2 сараар нэмэгдэнэ
1984 он ба түүнээс хойш	68 нас

- Шимтгэл төлж ажилласан байвал зохих 30 жилийн хугацаанд Монгол Улсад шимтгэл төлсөн хугацааг оруулан тооцно.

Бүрдүүлэх материал:

- Тухайн улсад ажиллаж байсан бол түүнийг нотлох өөрт байгаа аливаа бүх баримт бичиг;
- Суралцаж байсан бол дипломын хуулбар
- Иргэний үнэмлэхний хуулбар эсхүл лавлагаа